


ЗӨВШӨӨРӨВ:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

..... Д.ОЧИРБАТ



БАТЛАВ:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
НҮҮР АМНЫ МЭРГЭЖЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

..... Б. БАЯРЧИМЭГ



ШҮДНИЙ ЭМЧИЙН
“ШҮДНИЙ ЕРӨНХИЙ ЭМЧИЛГЭЭ СУДЛАЛ”
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Индекс : S(r) 091205

Хугацаа: 2 жил

УЛААНБААТАР ХОТ

2024 он

БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ:

Ж. Үржинлхам	Анангаахын шинэжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын сургуулийн Нүүр амны эмчилгээний тэнхимийн багш, Анагаах ухааны доктор, профессор
Ц. Норовпил	"Ач" Анагаах ухааны их сургуулийн багш, Монгол Улсын Гавъяат Эмч, Анагаах ухааны доктор, профессор
Б. Баярчимэг	Анангаахын шинэжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын сургуулийн Шүдний тулгуур эд, сувгийн эмчилгээний тэнхимийн багш, Анагаах ухааны доктор, дэд профессор

ХАМТРАН АЖИЛЛАСАН

Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлийн төлөөлөл:

Б.Энхбаатар	Эрүүл мэндийн яамны дэргэдэх Нүүр ам судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн дарга
-------------	---

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн төлөөлөл:

М. Батсуурь	Нүүр ам судлалын сургуулийн Нүүр амны эмчилгээний тэнхимийн багш, Анагаах ухааны магистр
П. Оюун-Энх	Нүүр ам судлалын сургуулийн Шүдний тулгуур, эд сувгийн эмчилгээний тэнхимийн багш, Анагаах ухааны доктор
Б. Оюунцэцэг	Нүүр ам судлалын сургуулийн Хүүхдийн нүүр ам судлал, урьдчилан сэргийлэлтийн тэнхимийн багш, Анагаах ухааны доктор, профессор
Б. Од	Нүүр ам судлалын сургуулийн Нүүр амны гажиг заслын тэнхимийн багш Анагаах ухааны доктор
А. Мөнхдөл	Ач Анагаах Ухааны их сургуулийн Нүүр амны мэс заслын тэнхимийн багш, Анагаах ухааны доктор
Б. Сапаар	Нүүр амны согог заслын тэнхимийн багш, Анагаах ухааны доктор

Эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл:

Ж. Билгээ	Дижитал дент шүдний эмнэлгийн захирал, АУ-ны доктор, Клиникийн профессор
-----------	--

ХЯНАСАН:

Н.Дашдондов	Эрүүл мэндийн яамны Стратеги төлөвлөлтийн газрын Салбарын хүний нөөцийн хөгжлийн хэлтсийн Салбарын хүний нөөцийн сургалт, мэргэшлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Д. Дондогмаа	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны үндсэн мэргэшлийн сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн

Эмнэлэгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн
01 дүгээр тогтоолоор зөвшөөрөв.

**ШҮДНИЙ ЭМЧИЙН “ЕРӨНХИЙ ЭМЧИЛГЭЭ СУДЛАЛ”
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ

Шүдний цоорол болон тулгуур эдийн өвчин нь хүн төрөлхтний дунд өргөн тархсан, архаг халдварт эмгэгүүд бөгөөд шүдгүйдэлд хүргэх үндсэн шалтгаануудын нэг болж байна. Сүүлийн жилүүдэд манай орны хүн амын ихээхэн хэсэг хот суурин газар шилжин амьдарч, амьдралын хэв маяг, үндэсний уламжлалт дадал заншил өөрчлөгдөн, нүүрс ус бүхий чихэрлэг хүнсний хэрэглээ ихэссэнтэй холбоотой хүн амын дунд ялангуяа бага насны хүүхдийн шүд цоорох өвчний тархалт, түүний хүндрэл жилээс жилд нэмэгдсээр байна. Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад цоорлын эрсдлийг урьдчилан тодорхойлж, нотолгоонд суурилсан эмчилгээ, урьдчилан сэргийлэлтийн аргыг хэрэгжүүлснээр энэ өвчний тархалтыг бууруулж байна. Тулгуур эдийн өвчин зүрх судасны өвчин, артеросклероз, зүрхний шигдээс, уушигны үрэвсэл, дутуу төрөлт, бага жинтэй хүүхэд төрөх зэрэг олон эмгэгийн эрсдэлт хүчин зүйл болж байгааг олон судалгаа баталсаар байна. Түүнчлэн амны салстын өвчнүүд, амны хавдрын урьдал өвчний тохиолдол нэмэгдсээр байгаагаар холбоотой оношилгоо эмчилгээний өндөр мэдлэгтэй, эмнэлзүйн болон харьцааны өндөр ур чадвар бүхий нарийн мэргэжлийн эмч бэлтгэх шаардлага гарч байна. Иймээс нүүр амны эмчилгээ судлалын чиглэлээр тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, өвчлөлийн тархалтыг бууруулах асуудал нэн чухлаар тавигдаж байна.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:

Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд нийцэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх цогц чадвар бүхий нүүр амны ерөнхий эмчилгээ судлалын эмч мэргэжилтэн бэлтгэхэд оршино.

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Шүдний эмчийн “Ерөнхий эмчилгээ судлал” -ын сургалтын хөтөлбөрөөр бэлтгэх эмч нь:

Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон, нүүр амны зонхилон тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээ хийхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн, өвчтөнд энэрэх сэтгэлээр хандаж, эмчийн ёс зүйг чандлан баримталдаг, багаар ажиллах чадвар эзэмшсэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үр дүнтэй үзүүлж чаддаг эмч байна.

**ДӨРӨВ. ШҮДНИЙ ЭМЧИЙН “ЕРӨНХИЙ ЭМЧИЛГЭЭ СУДЛАЛ” -ЫН
ЭМЧИЙН ЦӨМ ЧАДАМЖ**

Алсын харааг биелүүлэхэд чиглэсэн дараах цөм чадамжтай байна:

1. Шүдний ерөнхий эмчилгээний эмч (*General Practitioner*)
2. Мэргэжлийн байх (*Professional*)
3. Суралцагч (*Learner*)
4. Харилцагч (*Communicator*)
5. Хамтрагч (*Collaborator*)
6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч (*Community Health Advocate*)
7. Зохион байгуулагч, манлайлагч (*Leader*)

Чадамж (Competency): Эмнэлэгийн мэргэжилтний мэдлэг, ур чадвар, үнэ цэн, хандлага зэрэг олон бүрэлдэхүүн хэсгийг агуулсан, ажиглагдахуйц хүчин-чадал чадварыг чадамж гэнэ.

ТАВ. СУРГАЛТЫН ЗОРИЛТ

Цөм чадамж бүхий эмч болохын тулд дараах дэд чадамжийг эзэмшиж, бие даан гүйцэтгэж чаддаг болно. Үүнд:

1. Шүдний ерөнхий эмчилгээний эмч (*General Practitioner*)

- Хүн амын дунд зонхилон тохиолдох амны хөндийн өвчний шинж тэмдгийг (*signs and symptoms*) таньж ялган оношлох, анхан шатны арга хэмжээ авах
- Өвчтөнөөс асуумж авах, бодит үзлэг хийх, өвчтөний сэтгэл зүй, нийгмийн нөхцөл байдлыг үнэлж, оношилгоо, эмчилгээ, хяналтын төлөвлөгөө, гаргаж хэрэгжүүлэх
- Орон нутгийн түвшинд хийгдэх оношилгоо, эмчилгээний гардан үйлдлийг бүрэн эзэмшиж, тусламж үйлчилгээгаюулгүй үзүүлэх
- Өвчтөний хувийн нууцыг хадгалах
- Өвчтөний өвдөлт, сэтгэл зовнилд анхаарал хандуулах
- Орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нөөц бололцоонд тулгуурлан, өвчтөнд үзүүлэх тусламж, үйлчилгээг шийдвэрлэх
- Эрүүл мэндийн байгууллагын бүртгэл болон тайлангийн маягтыг зохих журмын дагуу цаг хугацаанд нь хөтлөх

2. Мэргэжлийн байх (*Professional*)

- Орон нутагт өөрийн мэргэшлээр хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзэлтэй байх
- Өвчтөнийг хувь хүний хувьд хүндэтгэж, хамгийн оновчтой зөв шийдвэр гаргахын төлөө ажиллах
- Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн асран хамгаалагч, төрөл садны хүнтэй хүндэтгэлтэй харилцах

3. Суралцагч (*Learner*)

- Өөрийн мэдлэг ур чадвараа дээшлүүлэхийн тулд хэрэцээт сургалтад хамрагдах
- Өдөр тутам шинэчлэгдэж байгаа анагаах ухааны дэвшлээс хоцрохгүйн тулд бие даан тасралтгүйгээр суралцах, олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг судлах, дүн шинжилгээ хийх
- Хамтран суралцагч эмч бусад эмнэлэгийн мэргэжилтэнд заах замаар өөрийн мэдлэг, ур чадвараа сайжруулах

4. Харилцагч (Communicator)

- Өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл садны хүнтэйзүй зохистой үг хэллэг ашиглан зөв боловсон харилцах
- Өвчтөнд шаардлагатай мэдээлэл өгөхдөө ойлгоход хялбар үг хэллэг ашиглан тайлбарлах
- Шаардлагатай тохиолдолд өвчтөний оношилгоо, эмчилгээний талаар бусад эмнэлэгийн мэргэжилтэнтэй зөвлөлдөх

5. Хамтрагч (Collaborator)

- Тухайн орон нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой асуудлаар мэргэшлийн эмч нартай мэдээлэл солилцож, хамтран ажиллах
- Эмнэлэгийн бусад тасгийн эмч, эмнэлэгийн мэргэжилтэнтэй мэргэжлийн мэдлэг, мэдээллээ хуваалцаж хамтран ажиллах

6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч (Community Health Advocate)

- Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байхын тулд урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээг үзүүлэх, сургалт сурталчилгаа явуулах
- Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх

7. Зохион байгуулагч, манлайлагч (Leader)

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг зохицуулах, манлайлан ажиллах үүргээ ухамсарлах
- Эмнэлэг, эрүүл мэндийн төв дэх тусламж үйлчилгээ үзүүлэх багийг манлайлан ажиллах үүргээ ухамсарлах

ЗУРГАА. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

6.1. Сургалтын чиглэл, хугацаа, байршил

- Сургалтын нийт хугацаа 2 жил байна. Тойролтын хугацааг сургалт эрхлэх байгууллага өөрийн онцлог, хүчин чадалд тохируулан зохицуулна.
- Сургалтын нийт хугацаанд шүдний эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээний сургалтыг сургуулийн эмнэлэг, гэрээт эмнэлгийг түшиглэн тойролтод заасан хугацаагаар явуулна.
- Суралцагч эмчийн өдөр тутмын болон 7 хоногийн үйл ажиллагааны тодорхой хуваарийг сургалт эрхлэх байгууллагаас боловсруулна.
- Эмнэл зүйн мэргэшүүлэх сургалт эрхлэх байгууллагад тавигдах шаардлага хангаж, эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөс Шүдний Ерөнхий эмчилгээ судлалын сургалт эрхлэх зөвшөөрөл авсан эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллага энэхүү сургалтыг явуулна.
- Их сургуулийн дэргэдэх эмнэлэг нь энэхүү сургалтын үндсэн байгууллага байна. Хэрэв сургалт явуулах хангалттай орчин бүрдээгүй тохиолдолд бусад эрүүл мэндийн байгууллагыг оролцуулан сургалт эрхлэх байгууллагын сүлжээ үүсгэн хамтарч ажиллана.
- Шүдний Ерөнхий эмчилгээ судлалын үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрөл авсан эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллага (сургалт эрхлэх байгууллагын сүлжээнд нэгдсэн бусад байгууллага)-ын амбулатори,

хэвтэн эмчлүүлэх тасаг, яаралтай тусламжийн тасаг, ариутгалын тасаг, нүүр амны мэс заслын, нүүр амны согог заслын, нүүр амны гажиг заслын, нүүр амны эмчилгээний, хүүхдийн нүүр амны тасаг, шүдний тулгуур эд, шүдний сувгийн эмчилгээ, амны салстын өвчин судлалын тасаг, хурлын танхим, сургалтын танхимд сургалт явагдана.

- Суралцагч нь сургалт эрхлэх байгууллага дээр зохион байгуулагдаж буй Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлага, Халдварын сэргийлэлт, хяналт, Амилуулах суурь тусламж, Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль, журам, зөрчлийн тухай хууль, хувь хүний нууц, хүний эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх, жендерийн тэгш байдалтай холбоотой хууль, журам, Эмнэлгийн эрх зүй, хөдөлмөрийн аюулгүй байдал, цацрагийн хамгаалалт, радиологи оношилгооны аюулгүй байдлын чиглэлээр сургалтанд (orientation) заавал хамрагдана.

6.2. Зайлшгүй танин мэдэж, суралцах шаардлагатай шинж тэмдэг, өвчин, гардан үйлдэл:

Сургалтын төгсгөлд орон нутагт бие даан тусламж, үйлчилгээ үзүүлж чадах түвшинд хүрэхийн тулд эмнэл зүйн сургагч багшийн хяналтан дор амбулаториор ирэх өвчтөний оношилгоо, эмчилгээг хариуцан хийх явцдаа дараах шинж тэмдэг, өвчин, гардан үйлдлийг гүйцэтгэж, туршлага хуримтлуулна.

6.2.1. Зайлшгүй таньж мэдэх Шинж тэмдэг (signs and symptoms)

1. Шүд өвдөх, аяндаа өвдөх, ямар нэгэн тодорхой шалтгаангүйгээр үүсдэг өвдөлт - Toothache, spontaneous pain or pain that occurs without any apparent cause.
2. Шүдний мэдрэмтгий байдал - Tooth sensitivity.
3. Чихэрлэг, халуун, хүйтэн зүйл идэж уух үед бага зэргийн хурц өвдөлт -Mild to sharp pain when eating or drinking something sweet, hot or cold.
4. Таны шүдэнд харагдахуйц нүх, цоорхой - Visible holes or pits in your teeth.
5. Шүдний аль ч гадаргуу дээр хүрэн, хар, цагаан толбо үүсэх - Brown, black or white staining on any surface of a tooth.
6. Хазах үед өвдөх - Pain when you bite down.
7. Муу амьсгалах - bad breath.
8. Шүдний буглаа - dental abscess (pus)
9. Хацрын эргэн тойронд хавдах - swelling around your cheek.
10. Тунгалагийн зангилаа хавдах - swollen lymph nodes.
11. Улайж хавдсан буйл - Red or swollen gums
12. Буйлнаас цус гарах - Tender or bleeding gums
13. Хазахад өвдөх - Painful chewing
14. Шүд унах - Loose teeth
15. Халууралт (Fever)
16. Толгой өвдөлт (Headache)
17. Ухаан алдалт, баларталт (Altered level of consciousness)
18. Таталт (Seizure)
19. Амьсгаадалт (Dyspnea)

20. Цээжээр өвдөлт (*Chest pain*)
21. Зүрх зогсолт (*Cardiac arrest*)
22. Дотор муухайралт, бөөлжилт (*Nausea, Vomiting*)
23. Сэтгэл гутрал (*Depression*)
24. Лимфийн булчирхайн томролт (*Lymph node swelling*)
25. Цус алдалт (*Hemorrhagic tendency*)
26. Чих шуугих (*Tinnitus*)
27. Толгой эргэх (*Vertigo*)
28. Хоолой өвдөх (*Sore throat*)
29. Залгихад түвэгтэй байх (*Dysphagia*)
30. Ам ангайлт хязгаарлагдах (*Trismus*)
31. Амнаас эвгүй үнэр гарах (*Halitosis*)
32. Хамар битүүрэх (*Nose blockage*)
33. Нүүр рүү чинэрч өвдөх (*Facial pain*)

Зайлшгүй танин мэдэж, суралцах өвчний эмгэг:

Цоорлын бус гаралтай хатуу эдийн эмгэгүүд:

- Цоохор шүд - *Mottled teeth* K00.3
- Шүд үүслийн хямрал - *Disturbances in tooth formation* K00.4
- Өөр бүлэгт ангилаагүй шүдний бүтцийн удамшлын гажиг-*Hereditary disturbances in tooth structure, not elsewhere classified* K00.5
- Шүдний хөгжлийн бусад эмгэг - *Other disorders of tooth development* K00.8
- Шүд цоорох - *Dental caries* K02
- Шүдний хатуу эдийн бусад өвчин - *Other diseases of hard tissues of teeth* K03
- Шүдний элэгдэл - *Excessive attrition of teeth* K03.0
- Шүд зүлгэгдэх - *Abrasion of teeth* K03.1
- Шүдний шалбархай - *Erosion of teeth* K03.2
- Шүдэлсний дараа шүдний хатуу эдийн өнгө хувирах - *Post-eruptive colour changes of dental hard tissues* K03.7
- Шүдний хатуу эдийн бусад тодорхой өвчин - *Other specified diseases of hard tissues of teeth* K03.8
- Шүдний хатуу эдийн өвчин тодорхойгүй - *Disease of hard tissues of teeth, unspecified* K03.9

Шүд цоорох өвчин:

- Шүдний паалангийн цоорол - *Caries limited to enamel* K02.0
- Тугалмайн цоорол - *Caries of dentine* K02.1
- Ясжмаг эдийн цоорол - *Caries of cementum* K02.2.
- Шүдний зогсонги цоорол - *Arrested dental caries*. K02.3.

Шүдний зөөлцийн үрэвсэл :

- Шүд эмгэгээр шимэгдэх - *Pathological resorption of teeth* K03.3.
- Шохойжсон ясжмаг - *Hypercementosis* K03.4.
- Шүдний хөгц, өнгрө - *Deposits [accretions] on teeth* K03.6.

- Шүдний зөөлц ба сурвалжийн оройн тойрон эдийн өвчин – *Diseases of pulp and periapical tissues* K04.
- Зөөлцийн үрэвсэл - *Pulpitis* K04.0.
- Зөөлцийн үхжилт үрэвсэл - *Necrosis of pulp* K04.1.
- Зөөлцийн дегенераци - *Pulp degeneration* K04.2.
- Зөөлцөд хатуу эд хэвийн бусаар үүсч хөгжих - *Abnormal hard tissue formation in pulp* K04.3.
- Зөөлцийн гаралтай сурвалжийн оройн тойрон эдийн үрэвсэл - *Acute apical periodontitis of pulpal origin* K04.4.

Сурвалжийн оройн тойрон эдийн үрэвсэл :

- Сурвалжийн оройн архаг үрэвсэл - *Chronic apical periodontitis* K04.5.
- Сурвалжийн оройн хөндийт буглаа - *Periapical abscess with sinus* K04.6.
- Сурвалжийн орой орчмын хөндийгүй буглаа - *Periapical abscess without sinus* K04.7.
- Сурвалжийн уйланхай - *Radicular cyst* K04.8.
- Зөөлц ба сурвалжийн оройн тойрон эдийн бусад ба тодорхойгүй өвчин - *Other and unspecified diseases of pulp and periapical tissues* K04.9.

Шүдний тулгуур эдийн үрэвсэл :

- Буйлны ба шүдний тойрон эдийн өвчин - *Gingivitis and periodontal diseases* K05.
- Буйлны цочмог үрэвсэл - *Acute gingivitis* K05.0.
- Буйлны архаг үрэвсэл - *Chronic gingivitis* K05.1.
- Сурвалжийн оройн тойрон эдийн үрэвсэл - *Acute periodontitis* K05.2.
- Сурвалжийн оройн тойрон эдийн архаг үрэвсэл - *Chronic periodontitis* K05.3.
- Пародонтоз - *Periodontosis* K05.4.
- Шүдний тойрон эдийн бусад өвчин - *Other periodontal diseases* K05.5.
- Шүдний тойрон эдийн өвчин, тодорхойгүй - *Periodontal disease, unspecified* K05.6.
- Буйл шамрах - *Gingival recession* K06.0.
- Гэмтэлийн гаралтай буйл ба шүдгүй түүшийн ирмэгийн эмгэг - *Gingival and edentulous alveolar ridge lesions associated with trauma* K06.2.

Амны салстын эмгэг:

- Амны салстын үрэвсэлтэй холбоотой эмгэгүүд – *Stomatitis and related lesions* K12.
- Амны салстын дахилтат афт - *Recurrent oral aphthae* K12.0.
- Амны салстын бусад хэлбэр - *Other forms of stomatitis* K12.1.
- Ам орчмын буглаа ба нэвчээс - *Cellulitis and abscess of mouth* K12.2.
- Амны шархлаат үрэвсэл - *Oral mucositis (ulcerative) Mucositis (oral) (oropharyngeal)* K12.3.
- Уруул ба амны салстын бусад өвчин – *Other diseases of lip and oral mucosa* K13.
- Уруулын өвчнүүд - *Diseases of lips* K13.0.

- Хацар ба уруулаа хазах - *Cheek and lip biting* K13.1.
- Лейкоплак ба амны хөндийн хучуур эдийн бусад эмгэг - *Leukoplakia and other disturbances of oral epithelium, including tongue* K13.2.
- Үсэрхэг лейкоплаки - *Hairy leukoplakia* K13.3.
- Амны салстын цочролоос үүссэн хиперплази - *Irritative hyperplasia of oral mucosa* K13.6.
- Амны салст бүрхэвчийн бусад тодорхойгүй эмгэг - *Other and unspecified lesions of oral mucosa* K13.7.
- Хэлний өвчнүүд – *Diseases of tongue* K14.
- Хэлний үрэвсэл - *Glossitis* K14.0.
- Газрын зуруг шиг хэл - *Geographic tongue* K14.1.
- Ромбо хэлбэрийн хэл - *Median rhomboid glossitis* K14.2.
- Хэлний хөхлөгийн хипертрофи - *Hypertrophy of tongue papillae* K14.3.
- Хэлний хөхлөгийн хатингаршил - *Atrophy of tongue papillae* K14.4.
- Атираат хэл - *Plicated tongue* K14.5.
- Хэл хорсох, өвдөх - *Glossodynia* K14.6.
- Хэлний бусад өвчин - *Other diseases of tongue* K14.8.
- Хэлний өвчин, тодорхойгүй - *Disease of tongue, unspecified* K14.9.

6.2.3. Зайлшгүй таньж суралцах гардан үйлдлийн жагсаалт

Амны хөндийн оношилгооны үйл явц - *Diagnostic procedures of oral cavity* 27.20

Нүүр амны мэс засал -*Maxillofacial surgery*

- Шүд авалт -*Extraction of tooth* 23
- Оношилж эмчилгээний төлөвлөгөө боловсруулан (Бахиар) шүд авах - *Diagnosis and treatment planning of extraction by forceps* 23.0
- Сүүн шүд авах - *Extraction of deciduous tooth* 23.1
- Бусад шүд авах- *Extraction of other tooth* 23.9
- Сурвалжийн орой тайрах- *Apicoectomy* 23.73

Нүүр амны эмчилгээ - *Restorative dentistry*

- Шүдийг нөхөн сэргээх - *Restoration of the tooth* 23.2
- Шүдний хатуу эдийн эмгэгийн оношилгоо ба эмчилгээний төлөвлөгөө боловсруулах- *Diagnosis and treatment planning of dental hard tissue defects* 23.2.0
- Шүдний цоорол - *Dental caries* 23.2.0.1
- Цоорлын бус эмгэг- *Non-caries disease* 23.2.0.2
- Хуванцар ломбоор ломбодох -*Composite resin filling* 23.2.1
- Гласс-Иономер цементээр ломбодох- *Glass-ionomer cement filling* 23.2.2

Хүүхдийн нүүр ам судлал - *Pediatric dentistry*

- Бусад шүдний нөхөн сэргээлт- *Other dental restoration* 23.4

- Сүүн шүдний эмгэгийн оношилгоо ба эмчилгээний төлөвлөгөө боловсруулах Diagnosis and treatment planning of deciduous tooth defect 23.4.1
- Шүдний цоорол - Dental caries 23.4.1.1
- Гласс-Иономер цементээр ломбодох- Glass-ionomer cement filling 23.4.1.2
- Сувгийн эмчилгээ - Root canal treatment 23.4.2
- Сувгийн өргөсөлт болон ломбодох - Root canal preparation and filling 23.4.2.1
- Байнгын шүдний урьдчилан сэргийлэлт, шүдний ховил ломбодох (силант)- Permanent tooth prevention (sealant) 23.4.3

Шүдний сувгийн эмчилгээ - Endodontology

- Сурвалжийн сувгийн оношилгоо ба эмчилгээний төлөвлөгөө боловсруулах Diagnosis and treatment planning of root canal therapy 23.7.0
- Шүдний хөндийг нээж хэлбэржүүлэх - Pulp chamber opening and cavity preparation 23.7.1
- Сурвалжийн суваг өргөсгөх - Root canal preparation 23.7.2
- Сурвалжийн суваг ломбодох Root canal filling 23.7.3
- Сурвалжийн сувгийг түр ломбоор ломбодох- Root canal temporary filling 23.7.3.1
- Сурвалжийн сувгийг байнгын ломбоор ломбодох - Root canal permanent filling 23.7.3.2
- Шүд ломбодох- Dental cavity filling 23.7.3.3
- Сурвалжийн сувгийг голонцороор сэргээх - Root canal restoration by post 23.7.3

Нүүр амны согог засал - Prosthodontology

- Бусад нөхөн сэргээлт Other dental restoration 23.4.9
- Согог заслын эмгэгийг оношилж эмчилгээний төлөвлөгөө боловсруулах- Diagnosis and treatment planning of prosthodontic defects 23.4.9.1
- Шүднээс хэв авах - Dental impression 23.4.9.2
- Хэсгийн авагддаг шүдэлбэр хийх - Partial denture 23.4.9.3
- Бүтэн авагддаг шүдэлбэр хийх - Full denture 23.4.9.4

Шүдний тулгуур эд судлал -Periodontology

- Буйлны бусад ажилбар -Other operation of gum 24.3
- Шүдний тулгуур эдийн эмгэгийг оношилж, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах Diagnosis and treatment planning of periodontal defects 24.3.1
- Амны хөндийн цэвэрлэгээ, чулууг цэвэрлэх - Scaling and root planning of oral cavity 24.3.1.1
- Буйлан дээрх чулууг авах - Gingival calculus curettage 24.3.1.2
- Буйлан доорх чулууг авах - Subgingival calculus curettage 24.3.1.2

Нүүр амны гажиг засал -Orthodontology

- Гажиг заслын зэмсэг хэрэглэх - Application of orthodontic appliance 24.7.0

- Оношилгоо, эмчилгээний төлөвлөгөө боловсруулж гажиг заслын зэмсэг хийх Diagnosis and treatment planning of orthodontic appliance 24.7.01
- Авагддаг зэмсэг Removable appliance 24.7.02

Амны салстын өвчин- Oral mucosa disease

- Амны хөндийн салстын оношилгоо, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах Diagnostic procedures of oral cavity and mucosa 27.20
- Амны салсын хэсгийн эмчилгээ -Topical treatment of oral mucosa 27.20.2
- Амны салстаас арчдасын шинжилгээ авах- Oral mucosa swab culture test 27.20.3

ТОЙРОЛТЫН АГУУЛГА

Шүд эрүү нүүрний эрхтэнүүдийн дүрс оношилгоо

- Шүд эрүү нүүрний эрхтнүүдийн эрүүл болон эмгэг өөрчлөлтүүдийг дүрс оношлогооны аргаар шинжлэх, нэг шүдний рентген зураг авах, эмгэг өөрчлөлтийн үед шинжилгээнд илрэх эмгэг шинжүүдийг илрүүлж оношлох, ялган оношлох чадвар эзэмшинэ.

Нүүр амны эмчилгээний материал судлал

- Нүүр амны эмчилгээний өрөөг зөв зохион байгуулах
- 4 болон 6 гараар ажиллаж чаддаг болох
- Нүүр амны эмчилгээнд хэрэглэгддэг эм материалыг зуурах, тавих, хадгалах, аюулгүй ажиллах

Нүүр амны мэс засал

- НАМЗ-ын өвчтөнд хэсгийн мэдээ алдуулалт хийх
- Оёдол тавих, авах
- Шүд авах ажилбараас үүдэлтэй хүндрэлүүдийг оношлох, саатсан шүдний байрлалыг тодорхойлох
- Нүүр амны идээт үрэвслүүдийг оношлох, анхны тусламж үзүүлэх
- Гурамсан мэдрэлийн симптоматик өвдөлтийг оношлох, анхны тусламж үзүүлэх
- Анафилаксийн шокийн үед анхны тусламж үзүүлэх
- Шүдний сурвалжийн оройг тайрах
- Гемисекц хийх
- Трансплантац хийх

Нүүр амны согог засал

- Загварлах, хэвлэх, шахах, цутгах ерөнхий аргыг эзэмших
- Тэвшлэх, чанах, өөлөх, зүлгэх, өнгөлөх сонгомол аргуудыг эзэмших
- Үүдэн ба араа бүлэг шүдний цөгцийг геометрийн аргаар дүрслэх
- Үүдэн ба араа бүлэг шүдний цөгцийг лавайгаар сийлэх
- Шүдийг урлахад хэрэглэгдэх багар, тоног төхөөрөмжтэй танилцаж, зөв барьж сурах, ашиглах
- Шүдний цөгцний согогийг оношлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах
- Өвчтөнд нарийн мэргэжлийн зөвлөгөө өгөх

Нүүр амны гажиг засал

- Гажиг заслын эмчилгээнд хэрэглэдэг материал, бахинууд, тоног төхөөрөмж

- Гажиг заслын эмчилгээний авагддаг зэмсгийг хуванцаржуулах, өнгөлөх
- Нүүр амны гажиг заслын авагддаг механик зэмсэг
 1. Нүүр амны гажиг заслын авагддаг механик зэмсгийн хэрэглээ
 2. Нүүр амны гажиг заслын авагддаг механик зэмсгийн төрөл, зохиомж
 3. Хийх арга техник
- Нүүр амны гажиг заслын авагддаг үйл зүйн зэмсэг
 1. Нүүр амны гажиг заслын авагддаг үйл зүйн зэмсгийн хэрэглээ
 2. Нүүр амны гажиг заслын авагддаг үйл зүйн зэмсгийн төрөл, зохиомж, ач холбогдол
 3. Хийх арга техник
- Нүүр амны гажиг заслын амны гаднах болон бөгжтэй зэмсгүүд
 1. Нүүр амны гажиг заслын амны гаднах болон бөгжтэй зэмсгүүдийн хэрэглээ
 2. Нүүр амны гажиг заслын амны гаднах болон бөгжтэй зэмсгүүдийн төрөл, зохиомж, ач холбогдол
 3. Хийх арга техник
- C-I зуултын гажгийн үед хэрэглэгдэх авагддаг төрөл, зэмсгийн зохиомж, ач холбогдол \эмнэл зүйн тохиолдолууд\
- C-II-1, C-II-2 зуултын гажгийн үед хэрэглэгдэх авагддаг зэмсгийн төрөл, зэмсгийн зохиомж, ач холбогдол \эмнэл зүйн тохиолдолууд\
- C-III зуултын гажгийн үед хэрэглэгдэх авагддаг зэмсгийн төрөл, зэмсгийн зохиомж, ач холбогдол
- Авагддаг зэмсгийг зүүх, хяналт тавих
- Зэмсгийг засварлах
- Бэхжүүлэгч зэмсэг
 1. Бэхжүүлэгч зэмсгийн ерөнхий зарчим
 2. Бэхжүүлэгч зэмсгийн ач холбогдол
 3. Авагддаг бэхжүүлэгч зэмсэг хийх

Хүүхдийн нүүр ам судлал, урьдчилан сэргийлэлт

- Хүүхдийн бие махбодийн өсөлт, хөгжил, үйл ажиллагааны онцлог, сэтгэл хөдлөл, оюун ухааны хөгжил, өвөрмөц онцлогийг харгалзан үзэж, хүүхдийн амны хөндийн менежментийг хэрэгжүүлэх мэдлэг, дадал, хандлагыг эзэмшинэ.
- Хүүхдийн шүд цоорох өвчин, түүний хүндрэлээс урьдчилан сэргийлэх, эмнэл зүйн үйл ажиллагааны үед хүүхдийн сэтгэл зүйг залах, айдасгүй эмчлэх мэдлэгийг эзэмшинэ.
- Хүүхэд, тэдний асран хамгаалагч нарт хүүхдийн ерөнхий биеийн хөгжил, нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хооллолт, амны хөндийн эрүүл мэнд, эрүүл мэндийн боловсрол олгох, амаа зөв арчлах мэдлэг, чадвар олгох болон сургалт явуулах мэдлэг, дадал, хандлагыг эзэмшинэ.

Шүд цоорох өвчин

- Шүд цоорох өвчнийг оношлох
- Толбыг нөхөн эрдэсжүүлэх эмчилгээ хийх чадвараа сайжруулах
- Цоорлын хөндийг гэрлээр хатуурагч хуванцараар ломбодох чадвараа
 - o сайжруулах

- Цоорлын хөндийг энгийн болон бондод амальгамаар ломбодох чадвараа сайжруулах
- Цоорлын хөндийг глассиономер цементээр ломбодох чадвараа сайжруулах
- Цоорлын эрсдлийг тооцож сурах
- Цоорлоос урьдчилан сэргийлэх аргуудыг эзэмшиж, нийгэм хамт олны дунд урьдчилан сэргийлэлтийг хийж чаддаг болно
- Хуванцар материалаар шүд пааландах
- Шүдний зайг хуванцар материалаар нөхөх

Шүдний хатуу эдийн эмгэг

- Хатуу эдийн эмгэгүүдийг ялган оношлох
- Үүдэн бүлгийн шүдэнд лабораторын бус аргаар нүүрэвч хийх
- Шүдний хатуу эдийг эрдэсжүүлэх
- Шүдний хүзүүний эмгэгийг урамсамхай болон паст хэлбэрийн хуванцарыг ашиглан сэргээх
- Шүд цайруулах эмчилгээ хийх

Шүдний сувгийн эмчилгээ

- Шүдний хөндийг нээж өргөсгөх
- Сувгийн уртыг хэмжих
- Суваг өргөсгөх алхам арагш аргуудыг эзэмших
- Сувгийг латералкондесацийн аргаар ломбодох
- Зөөлцийн болон сурвалжийн оройн тойрон эдийн үрэвслийг ялган оношлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах
- Сувгийн эмчилгээний тавиланг тооцох
- 1 болон олон сурвалжтай шүдний зөөлцийн үрэвслийг цогцоор нь эмчлэх
- Суваг өргөсгөх алхам доошоо аргыг эзэмших
- Уян багажаар суваг өргөсөх
- Сувгийг латераль болон бусад аргуудаар ломбодох
- Сурвалжийн оройн тойрон эдийн үрэвслийг ялган оношлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах
- Сурвалжийн оройн тойрон эдийн үрэвслийг эмийн аргаар эмчлэх
- Сувгийн дахин эмчилгээ хийх

Шүдний тулгуур эдийн тойролт

- Буйл шүдний эмгэг хөндийг тодорхойлох
- Бэхлэгдсэн холбоосын түвшин тодорхойлох
- Цус гаралтын зэрэг тодорхойлох
- Шүдний хөдөлгөөн тодорхойлох
- Үүдэвчийн гүн тодорхойлох
- Өнгөрийн хувь тодорхойлох
- Буйлны хэмжээг тодорхойлох
- Сурвалж хамарсан шимэгдлийн зэрэг тодорхойлох
- Шүдний тулгуур эдийн эрүүл болон зонхилон тохиолдох эмгэг өөрчлөлтүүдийг дүрс оношлогооны аргаар шинжлэх, эмгэг өөрчлөлтийн үед шинжилгээнд илрэх эмгэг шинжүүдийг илрүүлж оношлох
- Шүдний тулгуур эдийн зонхилон тохиолдох эмгэгийн шалтгааныг тодорхойлох
- ШТЭ-ийн зонхилон тохиолдох эмгэгийг ялгаж оношлох

- Шүдний тулгуур эдийн яаралтай тусламж үзүүлэх
- Ясны шимэгдэлтэй болон хөдөлгөөн ихтэй шүдэнд тулгуур эдийн сплинт тавих
- Амны эрүүл ахуйн бүтээгдэхүүн сонгож зөвлөх, аргачлал заах

Амны салстын өвчин

- Өвчтөнд нүүр амны гадуур ба дотуур үзлэг хийх
- Салст дээр гарсан морфологи элементүүдийг ялгаж таних
- Ялган оношлох
- Эмээр шавшлага хийх
- Цусны ерөнхий шинжилгээг уншиж дүгнэлт өгөх
- Дархлааны эсийн дэлгэрэнгүй шинжилгээг уншиж дүгнэлт өгөх
- Эмгэг шинж тэмдгийг илрүүлэх
- Шинжилгээг үнэлэх
- Ялган оношлох
- Эмчилгээг төлөвлөх

Яаралтай тусламж

- Толгой, хүзүү, нурууны гэмтэл (суурь тусламж, тээвэрлэлт),(Head, neck and spine injury(initial management and transportation))
- Амьсгалын зам гадны биетээр бөглөрөх, живэх (Foreign body abstraction Drowning)
- Тархианд цус харвах (цочмог үеийн),(Stroke (acute phase)
- Зүрхний дутагдал, зүрхний шигдээс (цочмог үеийн)(Heart failure, Myocardial infarction (acute phase)
- Шок (Shock)
- Цочмог хордлого (Poisoning, Intoxication)
- Могой шавьжинд хазуулах (хачир) (Snake bite, insect bite (tick bite)
- Буглаа (Abscess)

Халдвар хамгаалал

- Ажлын байрны халдвар хамгаалал
- Ариутгалын төрөл, ариутгал хийх арга техник
- Ариун багаж тоног ттөхөөрөмжөөр ажиллах зарчим

ТОЙРОЛТЫН ХУВААРЬ

№	Тойролтын нэр	Үргэлжлэх хугацаа	Тойролт хийх газар
1	Шүд эрүү нүүрний эрхтэнүүдийн дүрс оношилгоо	2 долоо хоног	Нүүр амны дүрс оношилгооны тасаг
2	Нүүр амны эмчилгээний материал судлал	6 долоо хоног	Нүүр амны эмчилгээний тасаг
3	Нүүр амны мэс засал	4 долоо хоног	Нүүр амны мэс заслын тасаг
4	Нүүр амны согог засал	4 долоо хоног	Нүүр амны согог заслын тасаг
5	Нүүр амны гажиг засал	4 долоо хоног	Нүүр амны гажиг заслын тасаг

			тасаг
6	Хүүхдийн нүүр ам судлал, урьдчилан сэргийлэлт	4 долоо хоног	Хүүхдийн нүүр ам судлал урьдчилан сэргийлэлтийн тасаг
7	Шүд цоорох өвчин	10 долоо хоног	Нүүр амны эмчилгээний тасаг
8	Шүдний хатуу эдийн эмгэг	8 долоо хоног	Нүүр амны эмчилгээний тасаг
9	Шүдний сувгийн эмчилгээ	14 долоо хоног	Нүүр амны эмчилгээний тасаг
10	Шүдний тулгуур эдийн тойролт	14 долоо хоног	Нүүр амны эмчилгээний тасаг
11	Амны салстын өвчин	14 долоо хоног	Нүүр амны эмчилгээний тасаг
12	Яаралтай тусламж	2 долоо хоног	Яаралтай тусламжийн тасагт
13	Халдвар хамгаалал	2 долоо хоног	Ариутгалын тасагт
	Бүгд	88 долоо хоног	

Загвар 1.

Ажлын байрны сургалт(On-the-Job Training)

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч/ хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Шүдний эмчилгээний тасгийн үзлэг	3-5	3 цаг 7 хоногт 2 удаа	Тасгуудад	Өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш
Хяналтын тойрон үзлэг хийх	3-5	Өдөр бүр 1 цаг	Тасгуудад	Өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш
Сургалтын тойрон үзлэг хийх	10 хүртэл	7 хоногт 1 удаа 1 цаг	Тасгуудад	Слайд	Эмнэл зүйн сургагч багш
Мэс заслын тасгийн үзлэгт оролцох	3-5	3 цаг 7 хоногт 2 удаа	Тасгуудад	Өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш
Согог заслын тасгийн үзлэг	3-5	3 цаг 7 хоногт 2 удаа	Тасгуудад	Өвчтөн	Эмнэл зүйн сургагч

					багш
Гажиг заслын тасгийн үзлэг	3-5	3 цаг хоногт удаа	7 2	Тасгуудад	Өвчтөн Эмнэл зүйн сургагч багш
Хүүхэд урьдчилан сэргийлэлтийн тасгийн үзлэг	3-5	3 цаг хоногт удаа	7 2	Тасгуудад	Өвчтөн Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч
Шүдний тулгуур эдийн тасгийн үзлэг	3-5	3 цаг хоногт удаа	7 2	Тасгуудад	Өвчтөн Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч
Сувгийн эмчилгээний тасгийн үзлэг	3-5	3 цаг хоногт удаа	7 2	Тасгуудад	Өвчтөн Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч
Амны салстын өвчний үзлэг	3-5	3 цаг хоногт удаа	7 2	Тасгуудад	Өвчтөн Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч
Рентгений үзлэг	3-5	3 цаг хоногт удаа	7 2	Тасгуудад	Өвчтөн Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч
Яаралтай тусламж	3-5	3 цаг хоногт удаа	7 2	Тасгуудад	Муляжин дээр Эмнэл зүйн сургагч багш
Халдвар хамгаалал	3-5	3 цаг хоногт удаа	7 2	Тасгуудад	Ариутгалын тасагт Эмнэл зүйн сургагч багш

Хяналтын тойрон үзлэг:

Үйлчлүүлж байгаа өвчтөний биеийн байдлыг суралцагч эмч нь эмнэл зүйн сургагч багшид (бусад эмч) танилцуулах зорилготой үзлэг. Үүний тулд суралцагч эмч нь урьдчилан бие даан өвчний түүх, сувилагчийн тэмдэглэлийг үзэж танилцан, өвчтөнтэй уулзаж асуумж цуглуулж (ганцаарчилсан үзлэг) эмнэл зүйн сургагч багшид

(бусад эмч) танилцуулахад бэлдэнэ. Танилцуулга хийхдээ хувь хүний мэдээллийг анхаарна. Танилцуулгыг сургалтын өрөө, танхим эсвэл өвчтөний өрөөнөөс гадна хийх ба өвчтөний орны дэргэдэх тойрон үзлэгийг эмнэл зүйн сургагч багштай (бусад эмч) хамт хийнэ. Хяналтын тойрон үзлэгээр өвчтөнөөс асуумж авах, үзлэг хийх аргад суралцана.

Сургалтын тойрон үзлэг:

Сургалтад тохиромжтой 1-2 өвчтөнг сонгож, өвчтөний биеийн байдлыг суралцагч эмч нь танилцуулах ба бусад оролцогчид (хамтран суралцагч эмч, эмнэл зүйн сургагч багш,, бусад эмч) асуулт тавьж, хэлэлцүүлэг өрнүүлнэ. 1 тохиолдолд 30-60 минут зарцуулна. Үүний дараа өвчтөний орны дэргэд үзлэг хийнэ. Хэлэлцүүлгийн явцад эмнэл зүйн таамаглал дэвшүүлэх, онош тавих зэрэгт суралцана.

Загвар 2.

Танхимын сургалт (On-the-Job Training)

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Бие даалт	1	Тохиромжтой чөлөөт цаг	Гэртээ, номын санд	Ном, интернет	Өөрөө, хамтран суралцагч эмч
Лекц	20 хүртэл	7 хоногт 2-3 удаа 1 цаг	Сургалтын анги, танхимд	Слайд	Эмнэл зүйн сургагч багш, хамтран суралцагч эмч
Журнал клуб	20 хүртэл	7 хоногт 1 удаа 1 цаг	Сургалтын анги, танхимд	Слайд, эрдэм шинжилгээний өгүүлэл	Эмнэл зүйн сургагч багш хамтран суралцагч эмч
Симуляци (дуураймал орчин)	5 хүртэл	7 хоногт 1 удаа 1 цаг	Үзлэгийн өрөөнд	Хамтран суралцагч эмч, манекин	Эмнэл зүйн сургагч багш

Загвар 3.

Үйл ажиллагааны хуваарь

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
08:30-12:30	Амбулаторийн үзлэг	Амбулаторийн үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Амбулаторийн үзлэг	Сургалтын тойрон үзлэг
12.30-13.30	Цайны цаг				
13:30-17:30	Семинар	Лекц	Мэс засалд орох	Семинар	Хэлэлцүүлэг
	Амбулаторийн үзлэг	Амбулаторийн үзлэг	Гардан үйлдэл	Амбулаторийн үзлэг	Бие даалт

ДОЛОО. ҮНЭЛГЭЭ, ЭРГЭН ЗӨВӨЛГӨӨ

7.1. Суралцагч эмч ба хариуцагч:

Сургалтын 2 жилийн хугацаанд суралцагч эмч бүрт хэрхэн ахин дэвшиж байгаа, хэрхэн сайжруулах тухай эргэн зөвлөгөө өгөх, суралцагч эмчийн хувийн төлөвлөгөөний (career plan) талаар зөвлөлдөх, тэднийг хариуцан ажиллах хүн (mentor) цаашид “хариуцагч” гэхийг оноож хувиарлана. Суралцагч эмч нь сургалт эхлэх үед хариуцагчтай уулзах ба цаашид 2-3 сар тутамд 1 удаа уулзаж ярилцан, үнэлгээтэй танилцаж, эргэн зөвлөгөө авна.

7.2. Суралцагч эмч ба эмнэл зүйн сургагч багш

Суралцагч эмчийн тойролт бүрт сургалт удирдах эмнэл зүйн сургагч багш оноож хуваарилна.

- Суралцагч эмч нь тухайн тойролт эхлэхээс өмнө эмнэл зүйн сургагч багштай уулзаж, тойролтын хугацаанд тавьсан зорилтоо ярилцана.
- Суралцагч эмч нь тойролтын явцад тавьсан зорилтод хүрэхийн тулд дутагдаж байгаа зүйл, түүнийг нөхөхөд хэрэгцээтэй байгаа зүйлийн тухай эмнэл зүйн сургагч багштай ярилцана.
- Суралцагч эмч нь тойролт дуусахад эмнэл зүйн сургагч багштай ярилцлага хийж, сургалттай холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө авна.

7.3. Үнэлгээний арга:

7.3.1. Төгсөлтийн шалгалт:

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулах Шүдний эмчийн “Ерөнхий эмчилгээ судлал” сургалтын төгсөлтийн шалгалт өгнө. Шалгалтанд тэнцсэн тохиолдолд Шүдний эмчийн “Ерөнхий эмчилгээ судлал” мэргэшигч эмчийн үнэмлэх олгоно.

7.3.2. Ажлын байранд суурилсан үнэлгээ (Workplace-based Assessment):

360 хэмийн үнэлгээ (360-Degree Assessment):

Суралцагч эмчийн мэргэжлийн байх (professionalism) болон зохион байгуулагч, манлайлагч (leader) байх зэргийг үнэлэхэд хэрэглэнэ. 2 жилийн сургалтын дунд үе болон төгсөх үед хийнэ. Тойролтыг удирдсан эмнэл зүйн сургагч багш, сувилахуйн мэргэжилтэн, өвчтөн зэрэг нийт 5 хүн тус тусдаа үнэлнэ. Үнэлгээ хийх хүнийг сургалтын албанаас сонгоно. Үнэлгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагчид өгнө.

Mini-CEX/Эмнэл зүйн дасгал үнэлгээ (Mini-Clinical Evaluation Exercise):

Зайлшгүй таньж мэдэх 22 шинж тэмдгээс тойролт бүрт 5-аас доошгүй шинж тэмдгийг тус бүр 3-аас доошгүй удаа, нийт 15-аас доошгүй удаа үнэлгээ хийнэ. Өөр тойролтонд ижил шинж тэмдгээр үнэлгээ хийсэн ч болно.

Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах зөвлөгөө заавал өгнө.

Гардан үйлдлийн ур чадварын шууд ажиглалт/DOPS (Direct Observation of Procedural Skills):

Зайлшгүй сурах 14 гардан үйлдлээс 11-ээс доошгүйг хийж чаддаг болсныг эмнэл зүйн сургагч багш нотолж, баталгаа өгөх хүртэл давтан үнэлгээ хийнэ.

Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас сурагцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах зөвлөгөө заавал өгнө.

Портфолио үнэлгээ (Portfolio Assessment):

Суралцагч эмч нь сургалтын хугацаанд суралцсан лекц, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний сургалтын үеэр эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа хийсэн материал зэрэг сургалттай холбоотой бусад бичиг баримтыг үр дүн болгож хадгална.

7.4 Үнэлгээний дүнг хянах

- 360-хэмийн үнэлгээний дүнг сургалтын алба хяналт тавьж, хадгална. Үнэлгээний дүнг суралцагч эмч, хариуцагчид танилцуулах ба бусадтай хуваалцахгүй байхыг анхааруулна.
- Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг суралцагч эмч өөрөө хадгална.
- Портфолиод үнэлгээ, эмнэл зүйн сургагч багштай зөвлөлдсөн асуудал, өгсөн зөвлөгөөг бичиж тэмдэглэн хадгална.
- Суралцагч эмч нь тойролт бүрийн төгсгөлд болон үнэлгээний дүнг сургалтын албанд хүлээлгэн өгнө.
- Сургалтын алба үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд танилцуулах ба сургалтын төгсгөлд хариуцагчаас суралцагч эмчид зөвлөгөө өгнө.

7.5 Сургалтын төгсөлтийг шийдвэрлэх

- Тойролт бүрт хийгдсэн Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг нэгтгэсний үндсэн дээр суралцагч эмчийг тухайн тойролтыг төгсгөх эсэх шийдвэрийг сургалтын хяналтын зөвлөл гаргана. Сургалтын хяналтын зөвлөл нь тойролт бүрт хийгдсэн Mini-CEX болон DOPS үнэлгээний дүн, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүн, суралцагчийн сургалтын ирц, зайлшгүй таньж мэдэж суралцах шинж тэмдэг, өвчний тохиолдол, гардан үйлдлийн тоог харгалзан сургалтын төгсөлтийн эцсийн шийдвэрийг гаргана. Шийдвэр гаргах шалгуур нь:
- Зайлшгүй сургалтад оролцсон байх өдрийн тоо буюу сургалтын ирц: Хөдөлмөрийн тухай хуульд заасан цалинтай амралтын өдрийн тоо, хүндэтгэх шалтгаантай авах амралтын өдрийн тоог оруулаад сургалтын хугацаанд авах амралтын өдрийн тоог сургалтын тойролт тус бүрийн нийт өдрийн 20%-аас хэтрүүлэхгүй байна. Сургалтын ирц хангалтгүй бол тухайн тасарсан сургалтын өдөр, агуулгыг нөхүүлнэ.
- Зайлшгүй таньж мэдэх шаардлагатай 22 шинж тэмдгээс 2 жилийн турш 18-аас доошгүйг оношилж, эмчлэн туршлага хуримтлуулсан байна. Зайлшгүй туршлага хуримтлуулсан байх шаардлагатай өвчний тохиолдлын тоо нь:
- ХНАСУС-ийн тойролт бүрт заагдсан өвчний бүх тохиолдлыг тус бүр 5-аас доошгүй удаа үзэж, туршлага хуримтлуулсан байна.

- НАМЗ-ын тойролтоор 30-аас доошгүй удаа шүд авч, 5-аас доошгүй тохиолдолд дээр ажиллаж, туршлага хуримтлуулсан байна.
- Яаралтай тусламж судлалын тойролтоор 2 жилийн турш зайлшгүй суралцах 10 төрлийн тохиолдлоос 8-ыг оношилж, анхан шатны тусламж үзүүлсэн байна.
- НАГЗ-ын 5 тохиолдолд ажиллаж, туршлага хуримтлуулсан байна.
- НАСЗ-ын 5 тохиолдолд ажиллаж, туршлага хуримтлуулсан байна.
- Тойролт бүрийн төгсгөлд эсвэл 1 жилийн сургалтын эцэст суралцагчийг төгсгөх боломжгүй гэсэн шийдвэр гарсан тохиолдолд шалтгаан, цаашид сургалтыг хэрхэн төгсгөх талаарх шийдвэр, зөвлөмжийг сургалтын алба болон хариуцагчаас тухайн суралцагч эмчид тайлбарлаж өгнө.

НАЙМ. ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

(хөтөлбөрийг нэвтрүүлэх ба хэрэгжүүлэх)

8.1 Сургалтын хяналтын зөвлөл

- Сургалтын албаны мэргэжилтэн, эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагын дэд дарга, НАЭ, НАСЗ, НАМЗ, НАГЗ, ХНАСУСТ, яаралтай тусламжийн тасгийн хариуцагч, тухайн тойролтын сургалт хариуцагч, сувилахуйн албаны төлөөлөл, эмнэлгийн захиргааны албаны төлөөлөл, суралцагч эмчийн төлөөллөөс бүрдэнэ. Сургалтын хяналтын зөвлөл нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагын даргын шууд удирдлага дор ажиллана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь сар бүр хуралдана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь суралцагч эмчийн сургалт, тулгарсан асуудалтай танилцах, суралцагч эмчтэй холбоотой бүх асуудлыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг судалдаг бүтэц байна.
- Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд нь сургалтыг илүү сайжруулахын тулд өөрийн мэдлэг, боловсролоо дээшлүүлэхийг зорьж ажиллана.

8.2 Хөтөлбөрийн хяналт

- Сургалтын алба хөтөлбөрт хяналт хийнэ.
- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардалагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнэл зүйн сургагч багшид чиглэсэн сургалт (Faculty Development), суралцагч эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.
- Хөтөлбөр нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд сургалтын хяналтын зөвлөлд оруулж хэлэлцүүлэн, өөрчлөлт хийнэ. Энэ тухай Эрүүл мэндийн хөгжлийн төвд албан бичгээр ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.

8.3 Сургалтын танилцуулга (Orientation)

Сургалт эхлэхийн өмнө тойролт бүрийн сургалтын төлөвлөгөө (Program) болон хөтөлбөрийн (Curriculum) агуулгын уялдааг тодорхой ойлгох, сургалт эрхлэх байгууллага (эмнэлэг, эрүүл мэндийн төв), түүний үйл ажиллагаа, эмчилгээ,

оношилгооны аюулгүй байдал, халдвар хамгааллын тухай суралцагч эмчид гүнзгий ойлголт өгөх зорилго бүхий танилцуулга хичээлийг зохион байгуулна.

Хавсралт 1

360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Суралцагч эмчийн нэр _____

Үнэлгээ хийгч: Эмнэл зүйн сургагч багш Сувилалд Бусад _____

Суралцагч эмчийг ажигласны үндсэн дээр, бусдаас сонссон, мэдсэн зүйл дээр бус, суралцагч эмчийн зан үйлийг хэр давтамжтай байсныг өөрийнхөө ажигласанаар оноо тавина уу.

☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Үнэлэх боломжгүй	Ховор (≤19%)	Заримдаа(20-49%)	Ихэнхдээ(50-79%)	Бараг бүгд (≥80%)

Өвчтөн/гэр бүлийн хувийн асуудлыг хүндэтгэх.	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Эмнэлгийн бичиг баримтыг бүрэн гүйцэт, гаргацтай, цаг хугацаанд нь хөтөлдөг.	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Орон нутгийн хүн амын эрүүл мэндийн асуудалд өөрийн санаачлагаар хувь нэмрээ оруулдаг.	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Өвчтөний бие даасан байдлыг хүндэтгэж, өвчтөнд тохирсон хамгийн зөв шийдвэрийг гаргахыг хичээн зүтгэл гаргадаг.	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөнийг хүндэтгэн эмчилдэг.	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Өөрийн эмнэл зүйн ур чадварыг дээшлүүлэхийн тулд сургалт болон бусад боломжийг алдалгүй ашигладаг.	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Өөрийн анагаах ухааны онолын мэдлэгээ дээшлүүлэхийн тулд бие даан суралцдаг.	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Орон нутаг дах бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажилладаг.	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Эмнэлэг доторх бусад эмч, мэргэжилтэнтэй хамтран ажилдаг.	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйг ухамсарладаг.	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Эмнэлэг доторх тусламж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйгээ ухамсарладаг.	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4

1 эсвэл 4 оноо тавьсан бол тухайн асуултын дагуу саналаа бичнэ үү.

Дүгнэлтийг тодорхой бичих хэрэгтэй. Жишээ нь: “Тэр бол найдваргүй” гэх нь тодорхой биш. Илүү хэрэг болох дүгнэлт бол: “Тэр сүүлийн 3 удаагийн журнал клубийн 2-т нь хэн нэгэнд урьдчилан мэдэгдэлгүйгээр оролцсонгүй.”

Өөрөөсөө асуу: **Миний дүгнэлт цаашид сайжрахад нь суралцагч эмчид хэрэг болох уу?”**

Хавсралт 2

ЯВЦЫН MINI-СЕХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Он, сар, өдөр / /
 Суралцагч эмчийн нэр: _____ Үнэлгээний нэр: _____
 Сургалт эрхлэх байгууллага: _____ Нэгж: _____ Газар: ☐ Клиник ☐ Тасаг ☐ ЯТТ ☐
 Бусад _____ Өвчтөний нас: _____ Өвчтөний хүйс: ☐ Эр ☐ Эм
 Өвчтөний зовиур: ☐ Халуурах ☐ Шарлах ☐ Толгой өвдөх ☐ Ухаан санааны байдал өөрчлөгдөх ☐ Татах ☐ Амьсгаадах ☐ Ханиах ☐ Цээжээр өвдөх ☐ Зүрх зогсох ☐ Цустай бөөлжих ☐ Цустай хар өтгөн гарах ☐ Дотор муухайрах/ бөөлжих ☐ Хэвлийгээр өвдөх ☐ Суулгах ☐ Усгүйжих ☐ Нуруу өвдөх ☐ Саажих ☐ Сэтгэл гутрах ☐ Хавагнах ☐ Үе өвдөх ☐ Лимфийн булчирхай томрох ☐ Цус алдах ☐ Бусад ☐ _____

Сайн талууд	Сайжруулахад чиглэсэн зөвлөгөө	Бусад санал

Сургалтын тухайн үед суралцагч эмчийг ямар түвшинд байгааг ажигласнаа үнэлнэ үү.
Бодит үзлэг хийх шаардлагагүй тохиолдолд тэмдэглэнэ үү:

Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай
Өвчний түүх авах			
Бодит үзлэг			
Оношилгоо, эмчилгээний менежмент			
Харилцааны ур чадвар			
Эмнэл зүйн ерөнхий чадвар			

Үнэлэгчийн гарын үсэг _____ Суралцагч эмчийн гарын үсэг _____

“Хангалттай” гэж тодорхойлоход хэрэглэгдэх үзүүлэлт	
Өвчний түүх авах	• Ялган оношилгоо хийхүйц дэлгэрэнгүй асуумж авдаг. • Өвчтөний хэрэгцээг илрүүлж, хариу үзүүлдэг. • Өвчтөний дохио зангааг ойлгож, тохиромжтой хариу үзүүлдэг
Бодит үзлэг	• Ялган оношилгоо хийхүйц дэс дараалалтай бодит үзлэг хийдэг • Үзлэгийн үед өвчтөнд таатай байдал бүрдүүлэхэд анхаардаг
Эмнэл зүйн менежмент	• Зөв онош тавидаг. • Оношилгоо, эмчилгээнд шаардлагатай шинжилгээ төлөвлөж, үр дүнг ашигладаг. • Тохирсон эмчилгээг эхлүүлдэг. • Тохирсон тасаг, эмнэлэгт шилжүүлдэг, цааш нь хяналт тавьдаг.
Харилцааны ур чадвар	• Өвчтөн , түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүн сайн сонсдог. • Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүний зовнилыг хуваалцаж, хүндэтгэлтэй ханддаг. • Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй эелдэг, энгийн үг хэллэг хэрэглэж харилцдаг.
Эмнэл зүйн ерөнхий чадвар	• Системтэй (харилцан уялдаатай) арга замыг тодорхойлдог. • Өвчтөний таатай байдал, аюулгүй байдлыг хангахад тодорхой идэвхи зүтгэл гаргадаг. • “Би гэр бүлийнхээ хэн нэгнийг энэ эмчээр эмчлүүлэхийг зөвшөөрч чадна.”

Хавсралт 3

ГАРДАН ҮЙЛДЛИЙН УР ЧАДВАРЫН ШУУД АЖИГЛАЛТ (DOPS)-ЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

.....он.....сар.....

Суралцагч эмчийн нэр: _____

Үнэлэгчийн

нэр _____

Сургалт эрхлэх байгууллага: _____ Нэгж: _____

Газар: ☐Клиник ☐Тасаг ☐ЯТТ ☐

Бусад _____ Өвчтөний нас: _____ Өвчтөний хүйс: ☐ эр ☐ эм

Гардан үйлдэл: ☐ Амьсгалын зам чөлөөлөх ☐ Өвчний түүх нээх ☐ Оёдол тавих ☐
 Шүдний цоорол ломбодох ☐ Сувгийн эмчилгээ хийх ☐ Шүдний тулгуур эдийн өвчнийг
 оношлох, эмчлэх ☐ Саатсан шүд авах ☐ Ёзоор авах ☐ Чиг тавих ☐ Шарханд анхдагч
 цэгцлэлт хийх ☐ Буйлны үрэвсэл, түүний эмчилгээ ☐ Рентген зураг унших ☐ Амны
 салстын өвчний оношилгоо, эмчилгээ ☐ Шүд цайруулах ☐ Шүдэнд нүүрэвч хийх ☐

Шүдийг сувгаар цайруулах ☐ Амны салстад шавшлага хийх ☐ Салстын үхжсэн эдийг авах ☐ Шүдний зай нөхөх ☐ Лабораторын шинжилгээнд дүгнэлт хийх ☐ Ам зайлуулах ☐ штифтээр шүдний цөгц сэргээх ☐ Файбар постоор шүдний цөгц сэргээх ☐_хуванцараар шүдэнд чиг тавих ☐ шүдний хоршилтыг тааруулах ☐_буйл тайрах ☐ шүдний гажиг засах авагддаг зэмсэг хийх ☐ шүдний гажигаас сэргийлэх зөвлөгөө өгөх ☐ өвчтөнөөс хэв авах ☐ авагддаг шахмал шүдэлбэрийг аманд тааруулах ☐ хүүхдийн шүдний эмчилгээ ☐ шүдний чулуу авах ☐ _____

Одоог хүртэл суралцагч эмчийн тухайн гардан үйлдлийн хийсэн тоо ____

Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай	Ажиглагдаагүй, үнэлэх боломжгүй
Хийх гэж буй үйлдлээ өвчтөнд тайлбарладаг, өвчтөнөөр зөвшөөрлийн хуудас бөглүүлдэг				
Гардан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хийдэг, багаж материалын сонголтоо зөв хийж бэлддэг				
Халдваргүйжүүлэх үйлдлийг гүйцэтгэдэг, багаж хэрэгслийн аюулгүй байдлыг хангаж хийдэг				
Арга техник чадварлаг гүйцэтгэдэг, зөв байрлал эвээр зөв хийдэг				
Өөрийн чадахгүй үйлдлийг ойлгож, шаардлагатай үед тусламж дууддаг				
Багаж хэрэгсэл, материалыг цэвэрлэдэг				
Шаардлагатай бичиг баримтыг гүйцэт бичдэг				
Зөвлөгөө өгч, хяналт тавидаг				
Гардан үйлдэл хийх ерөнхий чадвар				

Зөвлөмж:

Суралцагч эмчийн үйлдлийн сайн талууд:

Суралцагч эмчийн үйлдэлд сайжруулахад чиглэсэн зөвлөгөө:

----- -----
Суралцагч эмчид өгөх эцсийн санал (нэгийг сонгох): ☐ Үйлдлийг гүйцэтгэх мэдлэг, чадвар хангалтгүй ☐ Сургагч багшийн хяналтанд үйлдлийг хийх /хянах түвшинг сургагч багш шийдвэрлэнэ/ ☐ Суралцагч эмч үйлдлийг бие даан хийх боломжтой ☐ Суралцагч эмч энэхүү үйлдлийг бусдад заах/бусдыг хянах боломжтой
Суралцагч эмчид өгөх БУСАД санал: ----- -----

DOPS үнэлгээ хийсэн хугацаа: _____ /мин/. Зөвлөгөө өгсөн хугацаа _____ /мин/

DOPS үнэлгээ хийсэн **БАГШИЙН** сэтгэл ханамж:

Бага 1 2 3 4 5 6 7 8 9 Их

DOPS -р үнэлүүлсэн **СУРАЛЦАГЧ ЭМЧИЙН** сэтгэл ханамж:

Бага 1 2 3 4 5 6 7 8 9 Их

Багшийн гарын үсэг: _____ Суралцагч эмчийн гарын үсэг _____

САНАМЖ:	“Хангалттай” гэж тодорхойлоход хэрэглэгдэх үзүүлэлт
Хийх гэж буй үйлдлийн заалт, эсрэг заалт, анатоми, үйлдлийг хийх аргачлалыг бүрэн ойлгож мэдэх	• Сургагч багшид үйлдлийн заалт, эсрэг заалт, холбогдох морфологи анатомийн бүтэц, үйлдлийн үе шат, үйлдлийг гүйцэтгэх аргачлал, хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийн заалт, эсрэг заалт, гаж нөлөө, болзошгүй эрсдэл, хүндрэлийн үеийн яаралтай тусламжийн талаар мэдлэгтэй, бүрэн тайлбарлаж чаддаг.
Хийх гэж буй үйлдлээ өвчтөнд тайлбарладаг, өвчтөнөөс зөвшөөрөл /зөвшөөрлийн хуудас авах	• Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагчид үйлдлийн талаар бүрэн гүйцэд, дэлгэрэнгүй, ойлгомжтой, энгийн үг хэллэг ашиглан зохих тайлбарыг өгдөг. • Өвчтөн үйлдлээс айсан, сэтгэл нь тогтворгүй, түгшсэн тохиолдолд зовнилыг ойлгож, хуваалцаж, хүндэтгэлтэй, тэвчээртэй ханддаг, сонирхсон асуултанд оновчтой хариулдаг. • Зөвшөөрлийн хуудас бөглөхөөс өмнө өвчтөн нь гардан үйлдлийн талаар зохих ойлголттой байгаа талаар нягталдаг. • Өвчтөнд итгэл, үнэмшил төрүүлдэг. • Өвчтөнөөс шаардлагатай ажилбарт зөвшөөрлийн хуудас бөглүүлдэг.
Гардан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хангадаг, үйлдлийн өмнөх нөхцлийг зөв үнэлэх	• Гардан үйлдлийг гүйцэтгэх төлөвлөгөөтэй. • Өвчтөний сэтгэл санаа, тайван байдлыг хангадаг. • Үйлдлийг гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн болон нэмэлт тоног төхөөрөмж, эд зүйлсийг бэлтгэдэг. • Ажилбарын өмнөх хяналтын хуудас бөглөдөг, ажилбарын явц болон ажилбарын дараахь хяналтын хуудас, бичиг баримтыг бэлтгэдэг. • Гардан үйлдэлд шаардлагатай хувцас, өмсгөлийг бэлтгэдэг. • Үйлдлийг гүйцэтгэхэд найрсаг, ээлтэй, дулаан, байгалийн гэрэлтэй, цэвэр орчин бүрдүүлдэг.
Өвчтөний аюулгүй байдлыг хангах	• Гардан үйлдэл хийгдэх өвчтөний овог, нэр, регистрийн дугаар болон бусад аргуудаар танин тодруулдаг. • Үйлдлийг гүйцэтгэхэд хэрэглэх/хэрэглэж болзошгүй тайвшруулах, мэдээ алдуулах эм, тарианы нэр, тун, хэрэглэх арга зэрэг чанар, аюулгүй байдлыг хангадаг. • Үйлдлийг гүйцэтгэхэд зөв зүү, тариурыг сонгож нягталдаг, чанар, аюулгүй байдлыг хангадаг.
Ариун материалтай зөв харьцдаг, халдваргүйжүүлэх үйлдлийг зөв гүйцэтгэдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэх	• Ариун бээлийг зөв задалж өмсөж, тайлдаг. • Ариун салфетка, ариун хөвөн бөмбөлөг, нэг удаагийн зүү, тариуртай зөв харьцдаг. • Үйлдлийг гүйцэтгэхэд шаардлагатай халдваргүйжүүлэх уусмалыг зөв ашигладаг. • Үйлдлийн талбайг зөв ариутгадаг. • Хурц үзүүртэй зүү, эмнэлгийн хэрэгслийг зөв ашиглаж устгадаг.
Гардан үйлдлийн арга техникийг бүрэн эзэмшиж чадварлаг гүйцэтгэх	• Гардан үйлдлийн стандарт, протоколыг чанд мөрддөг. • Гардан үйлдлийг өөртөө итгэлтэй, чадварлаг гүйцэтгэдэг. • Зааварчилгааг тод, чанга дуугаар, ойлгомжтой өгдөг. • Зүү, тариур, тоног төхөөрөмжийг чадамгай ашигладаг. • Цус алдах болон бусад эрсдлээс сэргийлдэг.
Гардан үйлдэл амжилтгүй байгааг ойлгож, шаардлагатай үед	• Үйлдэл амжилтгүй байгааг өвчтөн, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сандарч тэвдэлгүй, зөв зохистой ойлгуулж мэдээлдэг. • Үйлдэл амжилтгүй гүйцэтгэсэнээ хүлээн зөвшөөрдөг.

тусламж дуудах	• Өвчтөн болон ажилчидтай тайван, зохистой харьцдаг. • Гардан үйлдлийг илүү сайн гүйцэтгэхэд бусдын тусламжийг хүсэж чаддаг. • Цаашид илүү амжилттай суралцах шаардлагатайг ухамсарладаг.
Үйлдлийн дараахь менежментыг зохистой хангах	• Суралцагч эмч нь гүйцэтгэсэн гардан үйлдэлд бодит үнэлгээ дүгнэлтийг өгч чаддаг. • Үйлдлийн дараахь эмчилгээ, асаргаа сувилгаа, халдвар хяналтын зөвлөмжийг өвчтөн болон эмнэлгийн ажилчдад амаар болон бичгээр зөв өгдөг.
Үйлдлийн үеийн харилцааны ур чадвар, хандлага	• Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүнийг сайн сонсдог, зовнилыг хуваалцаж, хүндэтгэлтэй ханддаг, эелдэг, энгийн үг хэллэг хэрэглэж харилцдаг. • Эмнэлгийн ажилчидтай хүндэтгэлтэй, эмнэлгийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг мөрдөж харьцдаг. • Хувь хүний нууцыг чанд сахидаг.
Үйлдлийн эмх цэгцгийг хангах	• Гардан үйлдлийн бүх үе шат нь тайван, эмх цэгцтэй, дэс дараатай гүйцэтгэдэг
Шаардлагатай бичиг баримтыг бүрэн гүйцэд гаргацтай цаг хугацаанд нь хөтлөх	• Гардан үйлдлийг зохих журам, зааврын дагуу баримтжуулдаг. • Гардан үйлдлийн баримтжуулалтын огноо, цаг, үг, өгүүлбэрийг тодорхой, гаргацтай бичдэг. • Гардан үйлдэл гүйцэтгэсэн суралцагч эмч нь нэр, гарын үсгээ тодорхой, гаргац сайтай баримтжуулдаг. • Гардан үйлдлийн баримтжуулалтыг сургагч багшаар баталгаажуулдаг.
Гардан үйлдэл хийх ерөнхий ур чадвар	• Өвчтөний аюулгүй байдлыг үйлдлийн бүх үе шатанд тасралтгүй хангадаг. • Гардан үйлдэл гүйцэтгэх мэдлэг хангалттай. • Гардан үйлдлийн ур чадвар хангалттай. • Гардан үйлдлийн үед гаргах шийдвэр, зааварчилгаа нь зөв. • Холбогдох тоног төхөөрөмж, нөөцийг зөв, зохистой ашигладаг.

НОМ ЗҮЙ

1. Ж. Үржинлхам, Б. Баярчимэг, М. Соёлмаа, П. Оюун-Энх, Х. Оюунхишиг “Нүүр амны эмчилгээ” сурах бичиг 2017 он. Улаанбаатар хот. ISBN-978-99973-76-42- 8.
2. Шүдний багаж, тоног төхөөрөмжийг ариутгах зааварчилгаа 2003
3. “Applied dental materials” John F. McCabe, Angus Walls. John Wiley & Sons, 9 ed, 2009
4. “The manual of dental assisting” Leah Vern Barnett, Elsevier, 4 ed, 2004
5. “Нүүр амны согор гажиг засал” сурах бичиг. Н.Пүрэвжав, Б.Амарсайхан. УБ 2005, 2009 он
6. “An introduction to removable denture prosthetics” Alan A. Grant 1983
7. “Porcelain& composite inlays& onlays” David A. Garber, 1994
8. Нүүр амны эмчилгээний эмнэлзүйн удиртгал – 2009 он
9. “Restorative dental materials” M. Graig, J.M. Powers, Mosby 2002

10. Dental materials", C.D. Hatrick, W.S. Eakle, W.F. Bird, Saunders Elsewiew, 2010.
11. "Sturdevant's Art and science of operative dentistry", T.M. Roberson *et al.*, Mosby 2006
12. "Preservation and restoration of tooth structure, R. Humm et al., 2008
13. Restorative dentistry" A.D. Wamsley, T.F. Walsh, F.J. Trevor Burke *et al*, Elsevier 2005
14. "Pickards manual of operative dentistry" E.A.M. Kid et al., Oxford 2002
15. "Master dentistry volume 1, 2" P. Heasman, Churchill Livingstone 2003
16. "Principles and Practice of Endodontics", R.E.Walton, M.Torabinejad, Saunders, USA, 2009
17. "Pathways of the Pulp", S. Cohen, R.C. Burns, Mosby, USA, 2011
18. "Endodontics therapy", Franklin S. Weine, Mosby, USA, 2004
19. "Color atlas of Dental Medicine Endodontology", R. Beer, M.A. Baumann, S. Kim, Elsevier 1996.
20. "Endodontics" Third edition, C. Stock, R. Walker, K. Gulabivala, 2004
21. "Contemporary oral and maxillofacial pathology", J.P. Sapp, L.R. Eversole, G.P. Wysocki, Mosby 2004
22. "Oral and maxillofacial pathology", B.W. Neville, D.D. Damm, C.M. Allen, J.E. Bouquot, Saunders 2004
23. "A color atlas of periodontology", J.D. Strahan, I.M. Waite, Wolf Medical Publications
24. "Periodontology. The essentials" H.P. Mueller, Thieme publications 2004
25. "Color atlas of periodontology", H. Klaus, E.M. Rateitschak, Thieme publications
26. "Clinical Periodontoloty" Carranza, Saunders 2002
27. "Color atlas of dental medicine: Radiology" F.A. Pasler, Thieme publications
28. "Oral radiology: principles and interpretation" S.C. White, Mosby 2004
29. "Нүүр амны мэс засал" Л. Хэнтий, Л. Давааням, Д. Уранчимэг, Ш. Даваахүү, Б. Батбаяр. Сурах бичиг: 2009 он
30. "Шүдний хатуу эдийн эмгэгүүд" сурах бичиг, Б. Оюунбат, 2006, 2014 он
31. "Oral & Maxillofacial Phathology" Nevile, Damm, Allen, Bouquot, 2002.
32. "Contemporary oral and maxillofacial pathology", J.P. Sapp, L.R. Eversole, G.P. Wysocki, Mosby 2004
33. "Oral and maxillofacial pathology", B.W. Neville, D.D. Damm, C.M. Allen, J.E. Bouquot, Saunders 2004
34. "Терапевтическая стоматология" Е.В. Боровский", 2003.
35. "Principles and Practice of Endodontics", R.E.Walton, M.Torabinejad, Saunders, USA, 2009
36. "Амны салстын өвчин" Ц. Норовпил, Б. Оюунбат 2005.
37. "Нүүр амны эмчилгээний салбарт хэрэглэгддэг эм бэлдмэлүүд" Б. Оюунбат, Б. Баярчимэг, Улаанбаатар, 2006
38. "Атлас по фантомному курсу по терапевтической стоматологии" Е.А. Магид, Н.А. Мухин, 2001
39. "Биология полости рта" Е.В. Боровский, В.К. Леонтьев, 2001
40. "Диагностика, лечение и профилактика стоматологических заболеваний" В.И. Яковлева и др. 1992
41. "Periodontology" J.D. Strahan, I.M. Waite 1980.

42. "Заболевания парадонта", Ф. Данилевский 1987
43. "Атлас заболеваний слизистой оболочки", Е.В. Боровский и др. 1987
44. <http://www.med.ucla.edu/modules/>
45. <http://www.whocollab.od.mah.se>